



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

Утааны яндан босгох ажилд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд КВМ-3,5 мвт халаалтын зуухны хэвийн ажиллагаанд шаардлагатай утааны яндан босгох ажлыг гүйцэтгэсүгэй.

2.Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Яндан шинээр босгох ажилд шаардагдах 5,111,000 (Таван сая нэг зуун арван нэгэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Илч-Орд ОНӨААТҮГазрын захирал (Д.Гантулга)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 08 дүгээр сарын 16 ны өдрийн
117 дугаар захирамжийн хавсралт



“ИЛЧ-ОРД” ОНӨААТҮГАЗРЫН КВМ-3,5 мвт ЗУУХНЫ
ЯНДАН ХИЙХ МАТЕРИАЛЫН ТӨСӨВ

Д/д	Материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Лист /20мм/	М ²	4	535 000	2 140 000
2	Круг төмөр /20мм/	м	135	8 600	1 161 000
3	Анкер боолт /41 толгойтой 27 мм голчтой 90см урттай/	ш	12	30 000	360 000
4	Чангалагч боолт /27мм голчтой 40см урт/	ш	9	42 000	378 000
5	Армотур	тн	1	500 000	500 000
6	Элс	тн	4	50 000	200 000
7	Хайрга	тн	3	40 000	120 000
8	Цемент	Ш	14	18 000	252 000
Нийт дүн					5.111.000